

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН 2019 ОНЫ 10 ДУГААР САРЫН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ

НЭГ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХҮРЭЭНД

Аймгийн Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнийг 2 удаа зохион байгуулж, нийт 30 үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг ханган ажилласан.

Монгол улсын Шадар сайдтай аймгийн Засаг даргын 2019 онд байгуулсан хамтран ажиллах гэрээнд тусгагдсаны дагуу “Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль”-ийг 2019 оны 10 дугаар сарын 09-12-ны өдрүүдэд зохион байгуулсан. Тус сургуулилтын нээлтийн үйл ажиллагаанд Онцгой байдлын ерөнхий газрын дэд дарга, аймгийн Засаг дарга, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, аймгийн Засаг даргын орлогч, Онцгой байдлын газрын дарга болон бусад зочид төлөөлөгчид оролцож, 52 байгууллагын 764 ажилтан, алба хаагч ёслолын жагсаалаар жагсаж, 23 байгууллагын 62 автомашины техник хэрэгслийн бэлэн байдал, хүн нэг бүрийн үүргэвчний иж бүрдлийг үзэж шалгалаа. Удирдах бүрэлдэхүүний команд штабын сургалтыг 10 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулсан бөгөөд нийт 148 төрийн алба хаагч ажилласан. Мөн 10 дугаар сарын 10-ны өдөр болзошгүй гамшиг, ослын үед нүүн шилжиж аюулгүй талбайд цугларах дадлага сургуулийг зарлан мэдээллийн дохио дуугарган эхлүүлж Сүмбэр сумын хэмжээнд тогтоосон түр цугларах 3 цэгт нийт 9500 иргэн нүүн шилжсэн. Шивээговь сумыг нүүлгэн шилжүүлэлтэнд 2476 иргэн, нийт 11976 иргэн нүүлгэн шилжүүлэлтэнд хамрагдсан байна. Тус аймагт гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулилт амжилттай зохион байгуулагдаж Дүүрэн хангалттай үнэлэгдсэн байна.

Эрчим хүчний тухай хууль, Эрчим хүчний хэмнэлтийн тухай хууль, Эрчим хүчний зохицуулах хорооны болон аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн тогтоол холбогдох дүрэм журмууд, хангагч байгууллагуудын дотоод дүрэм журам, үнэ тариф зэргийг иргэдэд таниулах, хэрэглэгчийн санал хүсэлтийг барагдуулах, аваар саатлаас урьдчилан сэргийлэх заавар зөвлөмж өгөх зэрэг мэдээ мэдээллийг цогцоор нь хэрэглэгчдэд хүргэх зорилгоор Аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлөөс санаачилан “Эрчим хүчээ хэрэглэе, хэмнэе” өдөрлөгийг аймгийн цахилгаан, дулааны эрчим хүчний байгууллагуудтай хамтран 2019 оны 10 дугаар сарын 25, 26-ны өдрүүдэд зохион байгууллаа.

ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮГИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

2019 оны 10 дугаар сарын Орон нутгийн татварын орлогын төлөвлөгөө 4398,1 мянган төгрөг төвлөрүүлэхээс, 5563,0 мянган төгрөг төвлөрүүлж 126.5 хувьтай байна.

2019 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар бүртгэлтэй ХК-1, ХХК-295, ББН-5, ЗБН-10, Хоршоо-27, ОНӨҮГ-6, Салбар-70, Хадгаламж зээлийн хоршоо-1, Төсөвт байгууллага-57, Төрийн бус байгууллага-89, Шашны байгууллага-5, Сан-10, Олон нийтийн байгууллага-16 нийт хуулийн этгээд 592 байна.

Орон нутгийн төсвийн байгууллагуудын 10091,2 сая төгрөг, Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудад 6221,8 сая.төгрөг, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн орлогын шилжүүлгийн 1688,0 сая төгрөгийн зарцуулалтын эрх төсвийн хуваарийн дагуу бүрэн нээгдэж төрийн сангийн гүйлгээ хэвийн явагдаж байна.

Сумдын төсвийн байгууллагуудын шинээр томилогдсон нягтлан бодогч нарыг чадавхижуулах сургалтыг 10 дугаар сарын 15, 16, 22-ны өдрүүдэд Санхүүгийн хяналт аудитын албатай хамтран зохион байгуулсан. Сургалтанд шинээр томилогдсон 29 нягтлан бодогч хамрагдсан.

Статистикийн чиглэлээр: 2019 оны 09 дүгээр сарын нийгэм, эдийн засгийн танилцуулгыг бэлтгэж аймгийн болон хэлтсийн цахим хуудсанд байршуулж хэвлэмэл хуудсаар 47, цахимаар 152 хэрэглэгчид хүргүүлсэн.

Санхүүгийн хяналт аудитын чиглэлээр: Төсвийн болон орон нутгийн өмчит байгууллагуудын 9 дүгээр сарын шилэн дансны мэдээллийг шалгахад 18 байгууллага хангалтгүй, 64 байгууллага хангалттай үнэлгээ авч хуулийн хэрэгжилт 78 хувьтай байна. Мөн 3 дугаар улирлын тайлан илгээлтийн байдалд хяналт тавихад 10 байгууллага хугацаа хоцроосон, 4 байгууллага тайлан илгээгээгүй байсныг нөхөн илгээлгэсэн.

Баянтал сумын 4 дүгээр сургууль, Шивээговь сумын 3 дугаар цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн үйл ажиллагаатай танилцаж ажилтан, албан хаагчдад санхүүгийн зөвлөгөө өгч, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн.

Нийгмийн даатгалын сангаас олгосон:Тэтгэвэр

| № | Төрөл | 2018.10.24 | | 2019.10.24 | | Шинээр тогтоолгосон |
|---|------------------|-------------|---------------------------|-------------|---------------------------|---------------------|
| | | Хүний тоо | Тэтгэврийн дүн /мян. төг/ | Хүний тоо | Тэтгэврийн дүн /мян. төг/ | |
| 1 | Өндөр настан | 1618 | 5229879,0 | 1731 | 5845453,5 | 113 |
| 2 | Тахир дутуу | 325 | 716594,0 | 367 | 837538,3 | 42 |
| 3 | Тэжээгчээ алдсан | 134 | 306333,5 | 129 | 308720,2 | -5 |
| 4 | Үйлдвэрийн осол | 58 | 219197,9 | 27 | 258467,1 | -31 |
| | Нийт дүн | 2135 | 6472004,4 | 2254 | 7250179,1 | 119 |

Нийгмийн даатгалын сангаас олгосон: Тэтгэмж

| № | Төрөл | 2018.10.24 | | 2019.10.24 | |
|---|-----------------|-------------|---------------------------|-------------|---------------------------|
| | | Хүний тоо | Тэтгэмжийн дүн /мян. төг/ | Хүний тоо | Тэтгэмжийн дүн /мян. төг/ |
| 1 | ХЧТА тэтгэмж | 1345 | 136817,9 | 1348 | 174341,2 |
| 2 | ЖБА тэтгэмж | 331 | 427701,3 | 328 | 510341,5 |
| 3 | Оршуулга | 66 | 66000,0 | 60 | 60000,0 |
| 4 | ҮОМШӨ-ХЧТА | 38 | 41541,4 | 11 | 4777,9 |
| 5 | Ажилгүйдэл | 166 | 272128,2 | 182 | 314392,6 |
| | Нийт дүн | 1946 | 944188,8 | 1929 | 1063853,2 |

Сайн дурын даатгал:

| Сайн дурын даатгалын хамрагдалт | 2018.10.24 | 2019.10.24 |
|---------------------------------|------------|------------|
| Шинээр | 210 | 240 |
| Мөнгө тушаасан | 637 | 645 |
| Тушаасан мөнгөн дүн / мян төг/ | 157640,4 | 213913,5 |

ГУРАВ. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Эрх зүйн сургалт, сурталчилгааны чиглэлээр: Аймгийн Засаг даргын Тамгын газар, Ахмадын хороо, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, Нийгмийн даатгалын хэлтэс, Нэгдсэн эмнэлэг, Төрийн архив, Монголын өмгөөлөгчдийн холбооны Говьсүмбэр аймаг дахь төлөөлөгч, Төрийн банк зэрэг байгууллагууд хамтран “Ахмад настан-Хэрэглэгч” өдөрлөгийг 2019 оны 10 дугаар сарын 02-04-ний өдрүүдэд зохион байгуулсан. Өдөрлөгт ахмад настнуудад нэгдсэн эмнэлгийн эмч анхан шатны үзлэг хийх, төрийн архиваас үнэ төлбөргүй мэдээлэл, лавлагаа гаргах, өмгөөлөгч үнэ төлбөргүй зөвлөгөө мэдээлэл өгөх, холбогдох

байгууллагууд шаардлагатай мэдээ мэдээллээр хангах зэрэг үйл ажиллагаа хийгдсэн бөгөөд давхардсан тоогоор 103 ахмад настанд үйлчилгээ үзүүлсэн.

2019 оны 10 дугаар сарын 03, 04-ний өдрүүдэд сумдад “Иргэдээ сонсьё” аяныг харъяа хэлтэс, агентлаг болон нотариат, Хүний эрхийн үндэсний комисс зэрэг байгууллагуудтай хамтран зохион байгуулж нийт 129 иргэнд мэдээлэл хүргэж, тараах материал өгч, төрийн үйлчилгээг хүргэсэн.

2019 оны 10 дугаар сарын 17, 18-ны өдрүүдэд хуулийн байгууллагуудын албан хаагчдад ёс зүйн харилцаа хандлагын талаарх танхимын сургалтыг зохион байгуулсан бөгөөд сургалтанд нийт 200 албан хаагч хамрагдсан.

Улсын бүртгэлийн хэлтэстэй хамтран Улсын бүртгэлийн хууль, тогтоомжийн талаар товч мэдээллийг 4400 иргэнд мессежээр хүргэсэн.

Архивын ажлын чиглэлээр:

Архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд 1 хөмрөгийн 1977-2001 оны 16 хадгаламжийн нэгжийн 215 заалт бүхий 4359 хүний нэр, 897 байгууллагын нэр, 2453 газар зүйн нэр, нийт 705 хуудас баримтыг цахимжууллаа. Архивын баримтаас 21 иргэнд лавлагаа мэдээллээр үйлчилгээ үзүүлсэн байна.

2019 оны 10 дугаар сарын 17-ны өдөр төрийн байгууллагын архив бичиг хэргийн албан хаагчдад Албан хэргийн стандарт, төрийн албан хаагчийн ёс зүй сэдвээр сургалт зохион байгууллаа. Сургалтанд 54 албан хаагч хамрагдсан.

Иргэний бүртгэлийн чиглэлээр:

- Шинээр гадаад паспорт захиалсан -26
- Иргэний үнэмлэх шинээр олгосон -47
- Төрснөө бүртгүүлсэн хүүхдийн тоо- 27
- Гэрлэлт бүртгүүлсэн тоо - 6
- Гэрлэлт цуцлуулснаа бүртгүүлсэн тоо -2
- Үрчлэлтийн бүртгэлийн тоо -2
- Овог, нэр өөрчлөлтийн бүртгэлийн тоо -1
- Нас барсныг бүртгүүлсэн тоо -6
- Өөр аймаг, хотоос шилжиж ирсэн нийт иргэн -11
- Аймаг дотор шилжсэн иргэдийн тоо -13

Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр:

- Үл хөдлөх хөрөнгийг анхны удаа баталгаажуулах бүртгэл -1
- Газар өмчлөх эрхийг анхны удаа баталгаажуулах бүртгэл - 25
- Гэрээний бүртгэл - 24
- Барьцааны гэрээний бүртгэл -164
- Эд хөрөнгөд орсон өөрчлөлт, залруулга -1

Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр:

- Шинээр байгуулагдсан хуулийн этгээдийн бүртгэл - 1
- Хуулийн этгээдийн бүртгэлийн өөрчлөлт -1

Архивын чиглэлээр:

- Төрийн байгууллагад гаргасан лавлагаа, хуулбар -36
- Иргэнд гаргасан лавлагаа, хуулбар-108

Нийт 502 иргэнд төрийн үйлчилгээг хүргэсэн байна.

Цагдаагийн хэлтэс нь:

Цагдаагийн хэлтэст иргэд, хуулийн этгээдээс 188 гомдол мэдээлэл хүлээн авч шалгаснаас 70 буюу 37,3 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 118 буюу 62,7 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл байна.

Гомдол мэдээллүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад Гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл 6-аар буюу 7.8 хувиар, зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл 11-ээр буюу 8.5 хувиар, нийт хүлээн авсан гомдол мэдээлэл 17-оор буюу 8.2 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр: Аймгийн хэмжээнд гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр нэгдсэн -3, хэсэгчилсэн-6, нийт 9 арга хэмжээн зохион байгуулан үр дүнг тооцлоо.

Хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 1, зам тээврийн хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр нэгдсэн 2, хэсэгчилсэн 3, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр 1, зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2, нийт 14 удаагийн сургалтыг зохион байгуулсан.

Галт зэвсгийн тухай хууль, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2015 оны А/220 дугаар тушаалаар батлагдсан “Галт зэвсгийн тооллого явуулах журам”-д заасны дагуу иргэн, хуулийн этгээдийн өмчлөлд байгаа галт зэвсгийн тооллогыг зохион байгуулж байна. Тооллогын явц 66 хувьтай явагдаж байна. Мөн галт зэвсгийн тухай хуулийн дагуу иргэн, аж ахуйн нэгж байгууллагууд галт зэвсгээ хэрхэн бүртгэлжүүлэх талаар зөвлөмж бэлтгэн цахим сүлжээгээр иргэдэд хүргэлээ.

“Нэг баг- Нэг зүрх” нээлттэй хаалганы өдөрлөгийн үеэр иргэдэд “Хүүхэд хамгааллын тухай хууль”, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль”, “Хүний биеийн эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг”-ийн талаар мэдээлэл өгч “Хүмүүжил бол эрхэм боловсрол”, “Хүүхэд таныг биш та хүүхдээ ойлгох ёстой”, “Гэр бүл дэх хүүхэд хамгаалал” зэрэг 7 төрлийн гарын авлага, материалыг 750 ширхэгийг иргэдэд хүргүүлсэн.

Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, аймгийн ИТХ-ийн тогтоол, Засаг даргын захирамжийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор “АРХИ-21” хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулж, согтууруулах ундаа худалдан борлуулдаг, түүгээр үйлчилдэг аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хийлээ.

Бага насны хүүхдүүд эцэг, эхийн хараа хяналт сул, тэдгээрийн хайхрамжгүй байдлаас алга болох, төөрөх, осол гэмтэлд өртөх явдал их байгаатай холбогдуулан цахим сүлжээгээр иргэдэд сэрэмжлүүлэг хүргэсэн.

“Улсын дугаар-2019” нэгдсэн арга хэмжээ үргэлжлэн явагдаж байгаа ба арга хэмжээний хүрээнд ашиглагдахгүй байгаа хасагдах тээврийн хэрэгсэл аймгийн хэмжээнд 140 байгаагаас 120 тээврийн хэрэгслийг улсын бүртгэлээс хасалт хийсэн.

Баянтал сумын нутаг дэвсгэрт явуулын постны орчим хурд хэмжигч багаж тогтмол ажиллуулан Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлийн 31 дэх заалтыг зөрчин замын хөдөлгөөнд оролцож тээврийн хэрэгслийн хурдыг зөвшөөрөгдсөн дээд хязгаараас 10-50 хүртэл хувиар хэтрүүлсэн 1209 жолоочийг 60 сая 450 мянган төгрөгөөр торгох шийтгэл оногдуулсан.

Шүүхийн шинжилгээний алба нь:

Шүүхийн шинжилгээний албанаас хэргийн газрын үзлэгт 17 удаа оролцсоноос хүний амь нас хохирсон хэргийн 3, хулгайн гэмт хэргийн 1, зам тээврийн ослын 7, бусад хэргийн газрын үзлэгт 6 удаа оролцож, Хэргийн газрын үзлэгийн болон эд мөрийн баримт, эрэн сурвалжлах, танин олуулах ажиллагаа, хэргийн газрын давтан үзлэг, нэгжлэг, цогцос задлан шинжлэх зэрэг ажиллагааны 590 кадр гэрэл зургийг боловсруулан холбогдох материалд хавсаргасан.

Тайлант хугацаанд хүний биед гэмтлийн зэрэг тогтоох үзлэг 23 удаа хийж дүгнэлт гаргасан. Мөн 1 цогцосны задлан шинжилгээнд оролцсон.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-425 дугаар нээлттэй хорих анги нь:

Гэмт хэрэг, түүний нийгмийн хор аюулыг ойлгуулах, хорих ялын зорилгыг хангах, нийгэмшүүлэх, сургалт, хүмүүжлийн ажлыг хоригдлын үйлдсэн гэмт хэргийн болон хувийн

байдал, нас зэргийг харгалзан төлөвлөгөөний дагуу өдөр бүр хоригдлуудад амьдрах ухааны сургалт зохион байгуулдаг. Мөн хар тамхины хэргээр ял эдэлж байгаа 12 хоригдолд бүлгийн сургалт зохион байгуулан ажиллаж байна.

Монгол бичгийн дугуйланг ажиллуулан 5 хоригдлыг хамруулан ажиллаж байгаа бөгөөд цаашид дугуйлангийн нэр төрлийг олшируулан ажиллахаар төлөвлөн ажиллж байна.

Суллагдах хугацаа дөхсөн хоригдлуудыг нийгэмшүүлэх тэдний хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэхэд анхааран ажиллаж сургалтын төлөвлөгөөний дагуу 18 хоригдолд “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль” болон нийгэм цаг үеийн байдал, нээлттэй ажлын байрны тухай мөн нийгмийн халамж үйлчилгээний байгууллагууд болон суллагдан гараад очих орон нутгийн замын маршрут, тээврийн зардлын талаарх сургалтыг зохион байгуулсан.

Мэргэжлийн хяналтын газар нь:

Төлөвлөгөөт шалгалт 7 газарт, төлөвлөгөөт бус 8, урьдчилан сэргийлэх хяналт 5 газарт, гүйцэтгэлийн хяналт, шалгалтыг 26 газарт хийж гүйцэтгэж, улсын байцаагчийн акт 11, албан шаардлага 13, дүгнэлт 4, зөвлөмж 1 тус тус гарган шалгалтад хамрагдсан аж ахуй нэгж байгууллага, иргэдэд хүргүүлсэн.

Хууль бус үр хөндөлтийг илрүүлэх, тэмцэх, аюултай үр хөндөлтөөс сэргийлэх, бууруулах, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах зорилгоор урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийв. Урьдчилан сэргийлэх хяналтаар ноцтой зөрчил илрээгүй бөгөөд анхан шатны бүртгэл маягтын хөтлөлттэй холбоотой илэрсэн зөрчлийг газар дээр нь арилгуулж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн. Манай аймгийн хэмжээнд 2019 оны эхний 10 сарын байдлаар хожуу болон аюултай үр хөндөлт бүртгэгдээгүй бөгөөд сүүлийн 3 жилд үр хөндөлтийн тоо буурсан үзүүлэлттэй байна.

Худалдаа, үйлчилгээний салбарын хөгжил, хандлага, хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэл, стандарт хөгжүүлэлтийн талаар суурь мэдлэг өгч, бизнесээ өргөжүүлэх боломж, нөхцөлүүдийг танилцуулах зорилгоор УБ-хот Худалдааны академи сургалтын төвтэй хамтран танхимын сургалтыг 2019 оны 10 дугаар сарын 20-ны өдөр зохион байгууллаа. Сургалтад худалдаа үйлчилгээний 24 аж ахуй нэгжийн 30 хүнийг хамруулж, 2 төрлийн 60 ш гарын авлага, зөвлөмж тараав.

Онцгой байдлын газар нь:

Аймаг орон нутгийн гамшгийн эрсдэлийг тодорхойлох, түүнээс үүдэлтэй учирч болох хохирлыг бууруулах, урьдчилан сэргийлэх, чадавхаа бэхжүүлж бэлэн байдлаа хангах хүрээнд 10 дугаар сарын 05-ны өдөр “Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөл”-ийн хуралдааныг зохион байгуулсан. Тус хуралдаанаар аймгийн хэмжээнд хийсэн “Гамшгийн эрсдэлийн тойм судалгаа”-ны үр дүнг зөвлөлийн гишүүдэд танилцуулж судалгаанаас гаргасан гамшгийн эрсдэлийг бууруулах зөвлөмжийг 2020 оны төлөвлөгөөнд тусгаж хэрэгжилтийг ханган ажиллах саналыг авах, 2019 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах зэрэг асуудлыг хэлэлцлээ.

Аж ахуй нэгж байгууллагын хүсэлтээр 4 байгууллагад ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт гарган 50 000 төгрөгийн тэмдэгтийн хураамжийг хуулийн дагуу орон нутгийн орлогод төвлөрүүлсэн.

ДӨРӨВ. БОЛОВСРОЛ,СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Боловсролын чиглэлээр: Монголын багш нарын баярыг угтан аймгийн хэмжээний боловсролын байгууллагын багш, ажилчдын дунд спортын 6 төрлөөр тэмцээнийг зохион байгуулж, нийт 200 багш, ажилчин хамрагдсан. Мөн 2019 оны 10 дугаар сарын 04-ний өдөр баярын хурлын үйл ажиллагааг зохион байгуулж Боловсролын “Тэргүүний ажилтан цол

тэмдэг"-ээр 12, БСШУСЯ-ны "Жуух бичиг"-ээр 4, аймгийн "Говьсүмбэрийн төлөө хүндэт медаль"-иар 9, аймгийн Засаг даргын "Жуух бичиг"-ээр 7 багш, ажилтныг шагнаж урамшуулсан.

Сүмбэр сумын 1, 2, 5 дугаар цэцэрлэгийн багш нарын хичээл, үйл ажиллагаанд арга зүйн зөвлөгөө өгч ажилласан бөгөөд 7 хоног бүр төрийн болон хувийн цэцэрлэгүүдийн ирцийн тандалтыг хийж, үйл ажиллагаа, санхүүгийн ажилд хяналт тавьж ажилласан

Ахмадын баярыг тохиолдуулан боловсролын салбараас өндөр настны тэтгэвэрт гарсан ахмад багш, ажилчдын уузалтыг 2019 оны 10 дугаар сарын 01-ний өдөр зохион байгууллаа. Тус арга хэмжээнд 87 ахмад настан оролцсон.

Боловсролын мэргэжил дээшлүүлэх институттэй хамтран "Иргэний ёс зүйн боловсрол хичээл"-ийн агуулга арга зүйн сургалтыг зохион байгуулж, сургалтанд бага анги, түүх нийгмийн ухааны 13 багш хамрагдаж, хичээлийн агуулга арга зүйн мэдлэг чадвараа дээшлүүлсэн.

"Ногоон паспорт-ногоон төгөл" аяны хүрээнд цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажилд 130 гаруй багш, сурагч оролцож мод тарьсан.

Аймгийн хэмжээнд энэ хичээлийн жилд 136 бүлгийн 3797 суралцагч суралцаж байна. Боловсрол, соёл шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/302 дугаар тушаал, ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдад сурах бичиг төлбөртэй ашиглуулах үйлчилгээний журам, "Төлбөрийн хэмжээ тогтоох тухай" тушаалын дагуу түрээсийн сурах бичиг ашиглах судалгааг ерөнхий боловсролын 1, 2, 3, 4, 5 дугаар сургуулийн хэмжээнд гаргасан. Үүнээс 6 дугаар ангийн сурах бичиг 78 багц, 7 дугаар ангийн сурах бичиг 100 багц, 8 дугаар ангийн сурах бичиг 48 багц, 9 дүгээр ангийн сурах бичиг 61 багц, 10 дугаар ангийн сурах бичиг 41 багц, 11 дүгээр ангийн сурах бичиг 51 багц, 12 дугаар ангийн багц шаардлагатай судалгааг гаргасан бөгөөд судалгааны дагуу сурах бичгийн хангалт хийгднэ.

Зүүн бүсийн математикийн олимпиадыг 2019 оны 10 дугаар сарын 19, 20-ны өдрүүдэд Шивээговь суманд зохион байгууллаа. Олимпиадад 5-12 дугаар анги, багш гэсэн 10 төрөлд 5 аймгийн 224 сурагч, 42 багш оролцсон. Олимпиадад багийн дүнгээр Сүхбаатар аймгийн багш, сурагчид тэргүүн байр эзэлсэн.

Спортын чиглэлээр: "Vizta" клубын нэрэмжит усан спортын нээлттэй тэмцээнд 2019 оны 10 дугаар сарын 12,13-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан. Тус тэмцээнд аймгаас 4 тамирчин оролцож 2 мөнгө, 5 хүрэл медаль хүртсэн амжилтыг үзүүлсэн.

Соёл, урлагийн чиглэлээр: Өвөрхангай аймгийн ЗДТГ, БСУГ, Хөгжимт драмын театр, Монгол хөөмий холбоо, Монголын Үндэсний урлагийн зөвлөл хамтран Монгол Улсын Соёлын тэргүүний ажилтан, Халхын алдарт хөөмийч Сэрхэний Зулсарын нэрэмжит хөөмийн уралдаан зохион байгуулагдаж, нийт 60 гурай уран бүтээлчид оролцсон. Тус уралдааны хамтлаг төрөлд Дуу Бүжгийн Боржигин чуулгын дэргэдэх "Хөх толботон" хамтлаг Тэргүүн байр "Гран при" шагналыг хүртсэн амжилтыг үзүүлсэн.

Хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжил, оролцоо, эрх хамгааллын чиглэлээр: Салбар дундын байгууллагуудын хамтран хэрэгжүүлж байгаа "Гэрээр айлчлагч" хөтөлбөрийн хүрээнд хүнд нөхцөлд амьдарч байгаа 1 өрхийг Дэлхийн Зөн олон улсын байгууллагад холбон зуучилсанаар хоол хүнсний дэмжлэг тусалцаа үзүүлээд байна.

Аймгийн хэмжээнд 2 хүүхэд хамгаалагч, сайн дурын ажилтнууд хамтран Сүмбэр сумын 1, 2, 3 дугаар багийн нутаг дэвсгэр, сургууль, цэцэрлэг, тоглоомын талбай орчимд хүүхдийг аливаа эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор өдөр бүр 4 цагийн эргүүлийн үүрэг гүйцэтгэж байна.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Цагдаагийн хэлтэс, аймгийн ЗДТГазрын Хууль, эрх зүйн хэлтэстэй хамтран 2019 оны 10-р сарын 18-ны өдөр "Эерэг хандлага-Эрүүл оюутан" аяны хүрээнд "ДЭВЖЭЭ-2019" тэмцээнийг зохион байгууллаа. Тус тэмцээнд ерөнхий боловсролын 4 сургууль, Политехникийн коллеж,

аймгийн хүүхдийн нэгдсэн зөвлөл нийт 6 багийн 42 хүүхэд оролцож, НҮБ-ын хүүхдийн эрхийн тухай конвенци, Хүүхдийн эрхийн тухай хууль, Тамхины хяналтын тухай хууль, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн хүрээнд мэдлэг олгож, тэдний авхаалж самбаа, ур чадварыг сорьж уралдлаа.

“Ирээдүйн эзэд” мэргэжил сонголтын үндэсний аяны хүрээнд аймгийн Боловсрол, соёл урлагийн газар, Политехникийн коллеж, “Хөгжлийн түүчээ сан” ТББ-тай хамтран ЕБС-ийн ахлах ангийн сурагчдад мэргэжил сонголтын чиглэлээр мэдээлэл хүргэх үйл ажиллагааг 2019 оны 10 дугаар сарын 02-ны өдөр зохион байгуулсан. Энэхүү арга хэмжээнд аймгийн ерөнхий боловсролын сургуулиудын 10-12 дугаар ангийн нийт 246 сурагч хамрагдсан. Сургалтын үр дүнд сурагчид өөрт тохирсон мэргэжлээ, хэрхэн яаж, зөв сонголт хийх талаар мэргэжлийн багш нартай уулзан зөвлөх үйлчилгээ авч, цаашид хүссэн мэргэжлээ эзэмшихийн тулд юу хийх ёстой талаар харилцан ярилцан мэдээлэл, үйлчилгээ авсан юм.

Үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх ардын өв уламжлалыг сурталчилах, хүүхдэдээ үлгэр уншиж өгч, үлгэрээр дамжуулан хүүхдэдээ ардын өв уламжлалыг таниулан, монгол ухаанаар амьдрах арга ухаанд суралцуулах, хүүхдийнхээ урам сэтгэмж, төсөөлөх чадварыг хөгжүүлэн хүмүүжүүлж буй аав, ээж, гэр бүлийг шалгаруулах, олон нийтэд таниулан сурталчилах, орой бүр хүүхдэдээ үлгэр уншиж өгдөг байхыг эцэг эхчүүдэд уриалах зорилгоор “ҮЛГЭРЧ ААВ, ЭЭЖ” аяныг аймгийн Нийтийн Номын сантай хамтран 2019 оны 09 дүгээр сарын 20-ноос 10 сарын 20-ны хооронд зохион байгуулсан. Аян 2 үе шаттай явагдаж, нийт 12 гэр бүл оролцсон.

Цахим орчныг эерэг болгох, залуучуудад эерэг мэдээлэл, эерэг санаачилга, сэтгэгдлийг түгээх, уриалах зорилгоор өсвөр үе, залуучууд, залуу гэр бүлүүд хэн нэгэн хайртай, дотны хүндээ зориулан талархлын үгээ захидлаар дамжуулан бичиж, шилдэг захидлуудыг шалгаруулах, олон нийтэд түгээх зорилгоор “Талархал” захидлын уралдааныг зохион байгуулсан. Тус уралдаанд нийт 113 захидал ирснээс 5 шилдэг захидлыг шалгаруулж, шагнаж урамшуулсан. Мөн шилдэг оролцогчдын захидлуудыг дуу оруулан цахим орчинд нийтлэн олон нийтэд түгээн эерэг мэдээлэл, нөлөөллийн ажил зохион байгуулсан.

Аж ахуй нэгж байгууллагын ажилтан, албан хаагчдын эрүүл мэндийг дэмжих, хөдөлмөрийн явцад бий болсон ядралыг сэргээх, ажлын чадварыг нэмэгдүүлэх, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор ажлын байрны дасгал хөдөлгөөнийг тогтмолжуулж, эрүүл зан үйлийг бий болгож олон нийтийн хандлагыг өөрчлөн, төрийн болон төрийн бус байгууллага, салбар дундын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх үүднээс “Эрүүл бие-Саруул ухаан” ажлын байрны дасгал хөдөлгөөний чөлленжийг цахим хуудсаар зарлан байгууллагуудыг чөлленжид дуудан идэвхижүүлж байна. Мөн 11 дүгээр сарын 02-ны өдөр “Эрүүл бие-Саруул ухаан” бүх нийтийн гимнастикийн тэмцээнийг зохион байгуулахаар төлөвлөөд байна. Энэ хүрээнд Биеийн тамир, спортын газар, Багачууд хөгжил ТББ-тай хамтран Үндэсний биеийн тамирын дээд сургуулийн гимнастикийн багшийг урьж дасгал хөдөлгөөний техник элементүүдийг заах сургалт зохион байгуулсан.

Эрүүл мэндийн чиглэлээр:

| Үзүүлэлт | 2018 оны 10 сар 20-ны байдлаар | 2019 оны 10 сарын 20-ны байдлаар |
|---------------------------|--------------------------------|----------------------------------|
| Төрсөн эх | 396 | 352 |
| Гэрийн төрөлт | 1 | 1 |
| Амьд төрсөн хүүхэд | 395 | 354 |
| Амьгүй төрөлт | 1 | 3 |
| Нас баралт | 54 | 41 |
| Эмнэлгийн нас баралт | 9 | 8 |
| Хоног болоогүй нас баралт | 3 | 3 |

| | | |
|-------------------------------------|-------|-------|
| 0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл | 1 | 4 |
| 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл | 2 | 0 |
| Эмнэлгээс гарсан хүний тоо | 4246 | 3709 |
| Амбулаторийн үзлэг | 92407 | 73410 |
| Халдварт өвчин | 214 | 132 |

Аймгийн Засаг даргын дэргэдэх эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын 4 дэх хурлаар 4 асуудлыг хэлэлцэж, “Гэгээн мандарваа ХХК-ны “Гэгээн мандарваа клиник эмнэлэгт уламжлалт анагаах ухааны чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгосон байна.

Өвөлжилтийн бэлтгэлийг хангах ажлын хүрээнд 2019 оны 09 дүгээр сарын 25, 26-ны өдөр Сүмбэр сумын хөдөөгийн багийн 60 өрхийн 120 иргэнд хүрч үйлчлэн үйлчилгээ үзүүллээ.

Монгол улсын Засгийн газрын дэмжлэгтэйгээр Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй “Эрүүл зүрх-Эрүүл хөдөлгөөн-Эрүүл ёс зүй” төслийн хүрээнд “Миний гэр бүл-Миний аз жаргал” өдөрлөг зохион байгууллаа. Энэхүү өдөрлөгөөр аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс, Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар хамтран эрүүл мэндийн салбарт ажиллаж буй 7 залуу гэр бүлийг алдаршуулан тэдний ажил үйлс, гэр бүлийн амжилтыг хуваалцах олон төрөлт арга хэмжээг зохион байгуулсан. Тус арга хэмжээнд эрүүл мэндийн салбарын 60 албан хаагч оролцсон.

Дархлаажуулалтын ээлжит 10 хоногоор заавал хийх дархлаажуулалт сахуу, татрангийн эсрэг дархлаа сэргээх тунд нийт 697 хүүхдийг 100 хувь хамрууллаа.

0-5 насны зорилтот бүлгийн хүн амыг улирлын томуугийн вакцинаар дархлаажуулах зорилгоор аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 4.5 сая төгрөгийг зарцуулсан.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын дэмжлэгээр Халдварт өвчин судлалын эмч мэргэжилтнүүдтэй хамтран эрсдэлт бүлгийн хүн амын дунд сүрьеэгийн илрүүлэг үзлэг зохион байгуулж 472 иргэнийг хамруулсан. Илрүүлэг үзлэгээр онош баталгаажуулах 49 сорьцыг Халдварт өвчин судлалын үндэсний төвийн лабораторид илгээж 1 тохиолдлыг эрт илрүүлсэн байна.

Аймгийн Засаг даргын 2019 оны А/303 дугаар захирамжаар “Цус эрүүл бол-Бие эрүүл 3” аяныг зохион байгуулж, Тэмбүү, Бэлгийн замаар дамжих халдвар илрүүлэг шинжилгээнд зорилтот 15-54 насны 7000 иргэн хамрагдахаас одоогийн байдлаар 4984 иргэн хамрагдаж, хүн амын хамралт 70 хувьтай явагдаж байна.

Дэлхийн гар угаах өдрөөр ерөнхий боловсролын сургуулиудын 1-3 дугаар ангийн 215 сурагч, цэцэрлэгийн гал тогоонд ажиллаж буй 21 ажилтанд гар угаах дадал эзэмшүүлэх, халдварт өвчнөөс сэргийлэх зан үйл төлөвшүүлэх ажлыг зохион байгуулсан.

Халамжийн чиглэлээр: 2019 оны 10 дугаар сарын 18-ны байдлаар нийт 6527 иргэнд 1681193178 төгрөгийг зарцуулсан байна.

| № | Үзүүлэлт | 2019.01.01-2019.09.19 | |
|---|---|-----------------------|------------|
| | | Хүн тоо | Мөнгөн дүн |
| 1 | Халамжийн тэтгэвэр | 259 | 394602930 |
| 2 | Нөхцөлт мөнгөн тэтгэмж | 286 | 186307950 |
| 3 | Амьжиргаа дэмжих мөнгөн тэтгэмж | 262 | 124872850 |
| 4 | Ахмад настнуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж, насны хишиг | 1082 | 101757475 |
| 5 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлсэн хөнгөлөлт, тусламж | 274 | 40651420 |

| | | | |
|---------------------------------------|---|-------------|-------------------|
| 6 | Жирэмсэн эхчүүдийн тэтгэмж | 427 | 57231530 |
| 7 | Цалинтай ээж | 1043 | 350276800 |
| 8 | Өрх толгойлсон эхийн тэтгэмж | 51 | 43634670 |
| 9 | Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж | 7 | 12151610 |
| 10 | Алдарт эхийн одонтой эхчүүдэд үзүүлэх мөнгөн тусламж | 1304 | 172660000 |
| 11 | Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ | 127 | 10250000 |
| 12 | Хүнс тэжээлийн дэмжлэгт услалцаа | 704 | 78515943 |
| 12 | Насны хишиг олголт | 701 | 108280000 |
| Нийгмийн халамжийн сангийн дүн | | 6527 | 1681193178 |

ТАВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Мал, аж ахуйн чиглэлээр:

Малын генетик нөөцийн төлөв байдлыг үнэлэх сургалтыг сумын Хөдөө аж ахуйн тасгуудын мэргэжилтэн болон “Сүмбэр хонь” цөм сүргийн үржлийн төвийн мал зүйчийг хамруулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамтай хамтран орон нутагт 2019 оны 10 дугаар сарын 16-18-ны өдрүүдэд зохион байгуулсан. Сургалтаар аймгийн нийт мал сүрэгт үүлдэрлэг байдлын үнэлгээ хийж, 2014, 2018 онуудад үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний харьцуулсан судалгаа, цаашид авах арга хэмжээний талаар санал, дүгнэлт гарган, тайланг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал үржил, бүртгэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт хүргүүлэв. Сургалтын явцад 4288 толгой малд үзлэг, ангилалтыг хийж гүйцэтгэсэн.

Аймгийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөцөд 2018 онд бэлтгэсэн 80 тн өнжсөн өвс, 26 тн тэжээл, Сүмбэр суманд 73 тн өвс, Баянтал суманд 20 тн өвс, 3.5 тн тэжээл, Шивээговь суманд 14 тн өвс, сумдын аюулгүйн нөөцөд нийт 107 тн өвс, 3.5 тн тэжээл нөөцөлсөн.

2019 оны 10 дугаар сарын 17-ны байдлаар хадлангийн 3 салаа, 3 иргэн Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймгийн зарим сумдад хадланд гарч 640тн өвс бэлтгэснээс 77 тн өвсийг малчдад борлуулж, 563 тн өвс нөөцөлсөн.

Сумдаас 43 малчин өрхийн хонин толгойд шилжүүлснээр 52607 малыг Дорнод, Хэнтий, Дорноговь, Дундговь, Төв аймагт оторлуулах саналаа ирүүлсэн.

2019 оны 10 сарын 16-ны байдлаар

| № | Сумдын нэрс | Өвөлжих малын тоо | | Үүнээс | | | | | | | |
|---|-------------|-------------------|-----------|---------------------|-----------|--------------------|-----------|---|-----------|----------------------------------|-----------|
| | | | | Аймаг дотор өвөлжих | | Өөр аймагт оторлох | | Аймаг дундын отрын бүс нутагт өвөлжих малын тоо | | Тусгай хамгаалалттай газар нутаг | |
| | | Өрх | Малын тоо | Өрх | Малын тоо | Өрх | Малын тоо | Өрх | Малын тоо | Өрх | Малын тоо |
| 1 | Баянтал | 145 | 103383 | 105 | 60085 | 27 | 33812 | 13 | 9486 | | |
| 2 | Сүмбэр | 723 | 432156 | 605 | 326171 | 16 | 18795 | 92 | 80756 | 10 | 6434 |

| | | | | | | | | | | | |
|---|---------------|------|--------|---------|--------|----|-------|-----|--------|----|------|
| 3 | Шивэ эговь | 143 | 71371 | 13 0 | 51111 | | | 13 | 20260 | | |
| | ДҮН | 1011 | 606910 | 84 0 | 437367 | 43 | 52607 | 118 | 110502 | 10 | 6434 |

Газар тариалангийн чиглэлээр: 10 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар төмс 9 га талбайгаас 70 тн, хүнсний ногоо 7.7 га талбайгаас 65.8 тн, тэжээлийн ургац 0.5 га-аас 2 тн ургац, буюу нийт 137.8 тн ургац хурааж, гүйцэтгэл 53.8 хувьтай байна.

2019 оны 10 дугаар сарын 20-ны өдөр МОРА ТББ-ын газар тариалан эрхлэгчдийн үйл ажиллагаа, ашиг орлогыг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд “ВАСАБИ тариалах арга технологи, экспортлох боломж” сэдвээр 6 цагийн сургалт зохион байгуулж газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч 11 иргэн хамрагдсан.

Монголын арьс, ширний үндэсний холбоо, Хөдөө аж ахуйн нэмүү өртгийг дэмжих төсөлтэй хамтран Улаанбаатар хотод “Мал, мах арьс шир, түүхий эд бэлтгэл, анхан шатны боловсруулалт” сэдэвт технологийн сургалт зохион байгуулж, мах боловсруулах үйлдвэрлэл эрхлэгч, түүхий эд бэлтгэгч 13 иргэн, аж ахуйн нэгжийн төлөөллийг хамруулсан. Тус сургалтаар махны үйлдвэрийн эрүүл ахуй, мал эмнэлэг ариун цэврийн шаардлага, мал, мах бэлтгэлд баримтлах технологи, дагалдах түүхий эд, арьс ширний ач холбогдол, анхан шатны боловсруулалт хийх арга ажиллагааны талаар танхмын болон үйлдвэрт нь очиж тодорхой мэдлэг, мэдээлэл олгосон.

Аймгийн төвийн захууд, томоохон худалдааны төвүүдийн хүнсний бараа бүтээгдэхүүний 10 дугаар сарын үнийн мэдээ

9 дүгээр сарын сүүлч, 10 дугаар сарын эхээр малчдаас зах зээлд нийлүүлэгдэж буй махны нийлүүлэлт өссөн. Зах зээлд худалдаалагдажбуй Үхрийн /ястай, цул/ махны үнэ 500 төгрөгөөр, адууны ястай мах 500 төгрөгөөр, хонины мах /ястай, цул/ 500 төгрөгөөр, ямааны мах /ястай/ 500 төгрөгөөр төмс болон зарим, хүнсний ногооны үнэ өнгөрсөн сараас 100-200 төгрөгөөр буурсан бол сүү /задгай/ 500 төгрөгөөр, ургамлын тос 50 төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Бусад бараа бүтээгдэхүүний үнэ тогтвортой байна

| № | Бараа бүтээгдэхүүн | | Дээд үнэ /төг/ | Доод үнэ /төг/ | Өссөн бүүрсан үзүүлэлт/+/- |
|---|--------------------|--------|----------------|----------------|----------------------------|
| 1 | Үхрийн мах | Ястай | 9500 | 8000 | 500 |
| | | Цул | 12000 | 11000 | - |
| 2 | Хонины мах | Ястай | 6500 | 5500 | -500 |
| | | Цул | 9000 | 9000 | -500 |
| 3 | Адууны мах | Ястай | 6500 | 5500 | -500 |
| | | Цул | 9500 | 9000 | - |
| 4 | Ямааны мах | Ястай | 6500 | 5500 | -500 |
| | | Цул | 9000 | 8500 | - |
| 5 | Тахианы мах | Гуя | 8500 | 8500 | |
| | | Мөч | 9200 | 8500 | |
| 6 | Лууван | Монгол | 2000 | 1500 | - |
| | | Хятад | | | |
| 7 | Төмс | Монгол | 1000 | 600 | -50 |
| | | Хятад | | | |
| 8 | Байцаа | Монгол | 1500 | 1200 | -300 |
| | | Хятад | | | - |

| | | | | | |
|----|------------------------|---------------------------------------|------|------|------|
| 9 | Чинжүү | Монгол | | | - |
| | | Хятад | 7000 | 6800 | |
| 10 | Манжин | Монгол | 1200 | 1200 | -50 |
| | | Хятад | | | - |
| 11 | Сонгино /бөөрөнхий/ | Монгол | 2000 | 1600 | - |
| | | Хятад | 1600 | 1200 | - |
| 12 | Улаан лооль | Монгол | 6000 | 5500 | - |
| 13 | Өргөст хэмх | Монгол | 3500 | 3000 | - |
| 14 | Элсэн чихэр | | 2100 | 1800 | - |
| 15 | Будаа | Цагаан будаа задгай 1кг /хятад/ | 2500 | 2000 | -100 |
| | | Шар слава 1кг | 3100 | 2900 | - |
| | | Гурвалжин слава 1 кг | 3800 | 2200 | - |
| 16 | Сүү | Задгай | 2000 | 1500 | +500 |
| | | Сүү ХК 0.5л 3.2% тослогтой | | | |
| | | Сүү ХК 1л 3.2% тослогтой | 3000 | 2950 | +300 |
| 17 | Тараг | Задгай | 2500 | 2000 | - |
| | | Сүү ХК 1л 3.2% цэцгийтэй | 4800 | 3800 | - |
| 18 | Талх | Чойр /Шивээ/ | 1200 | 800 | - |
| 19 | Өндөг | ОХУ | 450 | 300 | -5 |
| | | Монгол | 400 | 250 | -15 |
| 20 | Алтан тариан гурил | Задгай дээд | 1480 | 1400 | - |
| | | Задгай 1-р зэрэг | 1100 | 1080 | - |
| | | Задгай 2-р зэрэг | 1000 | 950 | - |
| | | Савлагдсан д/дээд | 1650 | 1600 | - |
| | | Савлагдсан дээд | 1650 | 1600 | - |
| | | Савлагдсан 1-р зэрэг | 1300 | 1200 | - |
| | | Савлагдсан 2-р зэрэг | 1500 | 1450 | - |
| 21 | Ургамлынтос | Олейна | 5500 | 4800 | +50 |
| | | Алтан | 3800 | 3600 | - |
| 22 | Гоймон | Алейка | 1600 | 1500 | - |
| | | А/т савхан | 1000 | 900 | - |

ЗУРГАА. БАЙГАЛЬ ОРЧИН, ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭ, ДЭД БҮТЦИЙН САЛБАРЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Байгаль орчны чиглэлээр:

Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас зохион байгуулж буй “Ногоон паспорт” аяны хүрээнд “Ногоон паспорт-Ногоон төгөл” модлог ургамлын цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажлыг 2019 оны 10 дугаар сарын 07-ны өдөр зохион байгууллаа. Тус арга хэмжээний нээлтийн үйл ажиллагаанд Аймгийн засаг дарга, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны ойн бодлого зохицуулалтын газрын дарга, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга, Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төвийн мэргэжилтэн, Говьсүмбэр аймгийн шилдэг ногоон паспорт эзэмшигч нар болон аймгийн байгаль орчны салбарт ажиллаж буй төрийн байгууллага, ерөнхий боловсролын 1,2,5 дугаар сургуулийн 130 гаруй сурагч, багш нар хамтран оролцож 11 төрлийн 500 ширхэг мод тарилаа.

2017 онд “Хог хаягдлын тухай хууль” /шинэчилсэн найруулга/ батлагдан мөрдөгдөж түүнтэй уялдан холбогдох зарим эрх зүйн актууд шинэчлэгдэн боловсруулагдан хэрэгжиж байгаатай холбогдуулан орон нутгийн зүгээс хог хаягдлын менежментийг сайжруулах зорилгоор 10 дугаар сард дараах цогц ажлыг зохион байгууллаа. Үүнд:

1. Аймгийн энгийн хог хаягдлын хэмжээ, бүтэц тодорхойлох судалгааны ажлыг гүйцэтгүүлэхээр даалгаврыг батлуулан холбогдох төрийн бус байгууллагад хүргүүлээд байна.

2. Монгол улсын Эрүүл ахуйн болон Хог хаягдлын тухай хууль, Засгийн газрын 2017 оны 98 дугаар тогтоолоор батлагдсан “Тогтвортой хөгжлийн боловсрол 2030” хөтөлбөрийн хүрээнд хүн амыг баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах талаар тусгасны дагуу орон нутгийн хүн амыг эрүүл аюулгүй орчинд амьдрах орчныг бүрдүүлэн сайжруулсан ариун цэврийн байгууламжийг иргэдийн өөрсдийнх нь санаачилга оролцоотойгоор барьж байгуулах урам сэдлийг иргэдэд өгч, тэднийг бодит өөрчлөлтөд уриалах, хамгийн ихээр дутагдаж буй санхүү, технологийн шийдлүүдийг танилцуулж, мэдлэг мэдээллийг олгох, хөрс бохирдуулагч жорлонгийн тоог үе шаттайгаар бууруулах зорилгоор “Жорлонгоо өөрчилъе” аян зохион байгуулахаар ажиллаж байна.

3. “Хог хаягдлын тухай хууль” /шинэчилсэн найруулга/, аймгийн “Агаар орчны бохирдлыг бууруулах дэд хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах, орон нутгийн хог хаягдлын менежментийг сайжруулах зорилгоор АОНХС-ийн “Агаар орчны бохирдлыг бууруулах дэд хөтөлбөр”-ийн хүрээнд “Хог хаягдлын менежментийг сайжруулах туршлага судлах” ажлыг аймаг сумдын шийдвэр гаргагч, хуулийн хэрэгжилтийг хангагч байгууллагын /АЗДТГ, Байгал орчин, аялал, жуулчлалын газар, Сум, багийн Засаг дарга, “Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ-ын нийт 14 албан хаагч 2019 оны 10 дугаар сарын 24-ний өдөр “Эрүүл мэнд, нийгмийн бодлогын хүрээлэн” ТББ-тай хамтран Улаанбаатар хотын хог хаягдлын менежментийн үйл ажиллагаатай танилцаж туршлага солилцлоо.

4. Шивээговь суманд 2019 оны 10 дугаар сарын 06-ны өдөр бүх нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулсан. Тус цэвэрлэгээнд сумын 1, 2-р багийн иргэд, ААНБ-уудыг оролцуулан нийт 300 гаруй хүн цэвэрлэгээнд хамрагдаж 8 га талбайн 60м³ хог хаягдлыг түүж цэвэрлүүлсэн.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээнд тусгагдсан төлөвлөгөөт ажлын хүрээнд Асгана булаг, Уулзварын голын эхийг хаших ажлыг 2019 оны 10 дугаар сарын 18-25 ны өдрүүдэд гүйцэтгэсэн.

Ус цаг уур орчны шинжилгээний төвөөс 10 дугаар сард 8 хугацааны мэдээг 248 удаа, хөдөө, аж ахуйн ажиглалтын хашаалсан талбайд 10, хашаалаагүй талбайд 3, хөрсний чийгийн ажиглалтыг 3, климат агро дундаж хөдөө аж ахуйн тойм мэдээ болон 10 хоногийн тойм мэдээг 3, сарын тойм мэдээг 1 удаа тус тус төв станцад дамжуулсан.

Агаар орчны шинжилгээний лаборатори нь агаар бохирдуулагч элементүүд болох азотын давхар исэл (NO₂) болон хүхэрлэг хийн давхар ислийг (SO₂) хоногт 14 удаа нийт 21 сорьцын дээж авсан ба азотын давхар исэл (NO₂) 0.011 мкг/м³, сарын хүлцэх агууламж нь 0.050, хүхэрлэг хийн давхар исэл (SO₂) 0.010 мкг/м³ байгаа нь зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс даваагүй хэвийн байна.

Тээвэр, авто замын талаар: Тээврийн хэрэгслийн техникийн үзлэг оношилгоонд 10 дугаар сарын 25-ны байдлаар 184, өссөн дүнгээр 2713 тээврийн хэрэгсэл хамрагдлаа.

Хот хооронд 570 иргэн, сум хооронд 145 иргэн зорчиж, 45 тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөн хийгдэн ачаа тээвэрлэлтийн 500 замын хуудас олгосон байна

Газрын харилцаа, барилга, хот байгуулалт, хөрөнгө оруулалтын талаар: Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 10 дугаар тогтоолоор 2019 онд газрын төлбөрийн орлого 163.8 сая төгрөг төвлөрүүлэхээр батлагдсан бөгөөд 10 дугаар сарын 24-ний өдрийн байдлаар 160.6 сая төгрөг төвлөрүүлж биелэлт 98 хувьтай байна.

Аймгийн Засаг даргын 2019 оны А/123 дугаар захирамжаар 6 байршилд 2019 оны 10 дугаар сарын 30-ны өдөр газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах эрхийн гэрчилгээний дуудлага худалдааг зохион байгуулахаар газрын цахим бирж болон байгууллагын цахим сайт, мэдээллийн самбарт зарыг байршуулаад байна.

Улсын болон орон нутгийн хөгжлийн сан, хувийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй 6 барилга байгууламжид ажил эхлүүлэх зөвшөөрөл олгож, 1 ажлыг ашиглалтад хүлээн авсан.

Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалттай барилга угсралт, засвар, шугам сүлжээний нийт 29 ажилд барилга захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж байна.

Худалдан авах ажиллагааны талаар: Аймгийн Иргэдийн Төлөөлөгчийн Хурлын 2018 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 05 дугаар тогтоолыг үндэслэн Улсын төсөв, аймгийн “Орон нутгийн хөрөнгө оруулалт”, “Орон нутгийн хөгжлийн сан”, “Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал”, “Авто замын сан”-гийн хөрөнгөөр хийгдэх худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж аймгийн Засаг даргаар батлуулан, Сангийн яам болон Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас зөвшөөрөл авч, “Төрийн худалдан авах ажиллагааны нэгдсэн цахим систем” болох www.tender.gov.mn сайтад байршуулж ил тод нийтлээд байна.

2019 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу 69 төсөл арга, хэмжээний үнэлгээний хороог байгуулж, худалдан авах ажиллагааг зохион байгуулж ажиллахаас 69 үнэлгээний хорооны захирамжийг гаргуулан биелэлтийг ханган ажиллаж байна. Тендер шалгаруулалтыг зохион байгуулсан 68, з арлагдаагүй 1 ажлын 2 багцын зургийн даалгавар захиалагчаас бүрэн батлагдаж ирээгүй байна. Гүйцэтгэл 98.5 хувьтай байна.

ДОЛОО. СУМ ОРОН НУТГИЙН ТАЛААР

Баянтал сум:

Сумын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах ажлын хэсэг 10 дугаар сарын 19-нд 2-р багийн 18 малчин өрхөөр орж, цаг үеийн ажлуудыг танилцуулж өвөлжилтийн бэлтгэл ажлын явцыг дахин шалгаж дутуу байгаа зарим ажлуудын гүйцэтгэлийг хангахыг малчдад анхааруулсан.

“Бид Монгол хаадын үргэлжлэл” хөвгүүдийн өдөрлөгийг зохион байгуулж ЕБСургуулийн нийт 38 хөвгүүн, “Бид Монгол хатадын үргэлжлэл” охидын өдөрлөгийг зохион байгуулж ЕБСургуулийн нийт 45 охин тус тус оролцсон байна. Өдөрлөгөөр “Монгол эмэгтэй”, “Монгол эр хүн” лекц, Хөгжөөнт буухиа тэмцээн уралдаан, “Охидын шивнээ”, “Би Монголын ирээдүй” сэдвээр чөлөөт ярилцлагыг зохион байгууллаа.

“Чулуун өв соёл”-ыг сурталчлах ажлын хүрээнд ЕБСургуулийн 7-9-р ангийн хүүхдүүдэд Чулуун өв соёл болон манай аймагт байгаа чулуун дурсгалуудын талаар мэдээлэл танилцуулга хийсэн.

Сүмбэр сум:

2019 оны 10 дугаар сарын 04, 06-ны өдрүүдэд хөдөөгийн 4, 5, 6 дугаар багийн өдөрлөгийг зохион байгууллаа. Өдөрлөгт 4 дүгээр багийн 136 иргэн, 5 дугаар багийн 52 иргэн, 6 дугаар багийн 76 иргэн, нийт 264 иргэн хамрагдсан. 5, 6 дугаар багийн өдөрлөгт аймгийн Засаг дарга оролцож, иргэдэд аймаг орон нутагт хийгдэж байгаа хөрөнгө оруулалтын ажлыг танилцуулж, малчдын сонирхсон асуултад хариулт өглөө.

2019 оны 10 дугаар сарын 18-ны өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63 дугаар зарлигаар жил бүрийн тав, аравдугаар сарын хоёр дахь долоо хоногийн бямба гарагийг “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-ийн хүрээнд Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газрын ажилтан, албан хаагчид Гомбосүрэн ноёны цэцэрлэгт хүрээлэнд намрын нөхөн тарилтыг хийж, усалгаа арчилгаа хийн ажиллалаа.

Шивээговь сум:

Тус суманд гамшгаас урьдчилан сэргийлэх “Нүүлгэн шилжүүлэх” иж бүрэн сургуулийг 2019 оны 10 дугаар сарын 11-ний өдөр зохион байгуулж газар хөдлөлтийн улмаас Шивээговь сумыг нүүлгэн шилжүүлэх ажиллагааг сумын Засаг даргын 2019 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн А/153 дугаар захирамжийн дагуу 3 цэг дээрээс иргэдийг 200 гаруй тээврийн хэрэгслээр тээвэрлэн сумын төвөөс ургаш 3,2 км-т хээрийн хотхонд 2476 иргэнийг иргэдийн бүс, Засаг захиргааны бүсүүдэд байршуулан төр, хувийн хэвшлийн бүх төрлийн үйлчилгээг үзүүлэх нөхцлийг бүрдүүлэн ажилласан.

Сумын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг боловсруулан сумын Иргэдийн төлөөлөгчдийн Хуралд хүргүүлээд байна.

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс баталсан ажилгүйдлийг бууруулах, хүн амын бүлгүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд “Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт хамрагдахаар 4 иргэн төсөл ирүүлснээс 3 төсөл дэмжигдэж гэрээ байгуулж санхүүгийн дэмжлэгийг олгоод байна. Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд бүлгийн зохион байгуулалттайгаар хүлэмжинд нарийн ногоо тариалах арга хэмжээнд зорилтод бүлгийн 4 иргэнийг хамруулан тариалалтыг хийж 771,1 кг өргөст хэмх хураан авч өрхийн орлогыг нэмэгдүүлээд байна.